



МОНГОЛЫН
ХӨРӨНГИЙН
БИРЖ

2019

7-Р САР

Э-сонин

72-р дугаар





Зах зээлийн тойм

/2019.07.31-ний өдрийн байдлаар/

1. Арилжаа явагдсан өдөр

20

2. Нийт арилжааны үнийн дүн /төгрөг/

16,247,842,924

Хувьцаа /анхдагч/

0

Хувьцаа /хоёрдогч/

16,237,442,924

Засгийн газрын үнэт цаас /хоёрдогч/

10,400,000

Компанийн бонд /анхдагч/

0

Компанийн бонд /хоёрдогч/

0

3. Нийт арилжигдсан үнэт цаасны тоо ширхэг

7,897,369

Хувьцаа /анхдагч/

0

Хувьцаа /хоёрдогч/

7,897,265

Засгийн газрын үнэт цаас /хоёрдогч/

104

Компанийн бонд /анхдагч/

0


Компанийн бонд /хоёрдогч/

0


4. Нийт хийгдсэн хэлцлийн тоо

3,102


Зах зээлийн үнэлгээ




TOP-20 индекс



MSE A индекс



MSE B индекс



Бүртгэлтэй хувьцаат компани

1. Нийт компанийн тоо	199
100% төрийн өмчит	18
Төрийн өмчийн оролцоотой	10
Хувийн өмчийн	171
I ангилал	14
II ангилал	44
III ангилал	140

Гишүүн үнэт цаасны компани

1. Гишүүн Үнэт цаасны компанийн тоо	57
Үүнээс: Брокер, Дилер	51
Андеррайтер	24
Хөрөнгө оруулалтын зөвлөх	13



Арилжаанд идэвхтэй оролцсон гишүүн үнэт цаасны компаниуд

/2019.07.31ний байдлаар/

Симб ол	Нэр	Үнэт цаас авсан		Үнэт цаас зарсан		Арилжааны дүн /авсан, зарсан/ (₮)
		Тоо ширхэг	Үнийн дүн (₮)	Тоо ширхэг	Үнийн дүн (₮)	
1	Ти Ди Би Капитал ХХК	1,118,522	14,359,663,260	1,342,235	14,416,466,021	28,776,129,281
2	БиДиСек ХК	861,289	367,485,003	899,124	396,051,628	763,536,631
3	Гаүли ХХК	989,256	359,726,190	445,516	160,135,635	519,861,825
4	Голомт Капитал ХХК	1,201,057	175,706,185	920,335	181,806,842	357,513,027
5	Ард секюритиз ХХК	1,841,532	230,759,708	746,967	107,785,224	338,544,932
6	Тулгат чандмань баян ХХК	28,781	9,194,520	169,022	292,838,609	302,033,129
7	Дэлгэрхангай секюритиз ХХК	11,525	264,221,100	0	0	264,221,100
8	Стандарт инвестмент ХХК	280,621	77,569,591	444,928	107,460,589	185,030,180
9	Бумбат-Алтай ХХК	126,738	32,264,493	395,085	101,562,241	133,826,734
10	Инвекор капитал ҮЦК	63,702	113,549,359	315	564,350	114,113,709
11	Мирэ Эссет Секюритис Монгол ХХК	924,413	59,852,890	529,491	43,017,911	102,870,801
12	Эм Ай Би Жи ХХК	51,502	30,960,600	9,031	66,574,160	97,534,760
13	Зэргэд ХХК	11,468	2,014,035	1,088,557	88,221,695	90,235,730
14	Апекс Капитал ҮЦК	109,101	19,533,439	151,209	59,654,407	79,187,846
15	Лайфтайм инвестмент ХХК	8,766	61,469,790	26,065	4,169,960	65,639,750
16	Новел инвестмент ХХК	68,099	15,017,094	230,474	35,788,227	50,805,321
17	Централ секюритиз ҮЦК	30,815	21,884,935	65,085	21,320,020	43,204,955
18	Монсек ХХК	39,445	16,269,204	46,587	9,876,494	26,145,698
19	Гранддевелопмент ХХК	4,825	297,509	3,338	24,701,200	24,998,709
20	Дархан брокер ХХК	18,271	3,906,013	108,031	20,053,213	23,959,226

Идэвхтэй арилжигдсан хувьцаа

/2019.07.31-ний байдлаар/

№	Сим- бол	Үнэт цаасны нэр	Арилжигдсан ширхэг	Үнийн дүн /₮/	Дээд Ханш	Доод Ханш	Өөрчлөлт /% /
1	MIK	МИК ХОЛДИНГ	926,453	14,299,513,340	16,000	14,930	-3.45
2	MBW	МОНГОЛ БАЗАЛЫТ	894,961	299,505,072	367	285	22.87
3	UBH	УЛААНБААТАР ХИВС	11,473	263,445,380	23,000	15,020	9.68
4	BDS	БИ ДИ СЕК	308,043	240,808,672	900	775	1.59
5	TTL	ТАВАН ТОЛГОЙ	26,952	196,979,735	7,420	6,610	-10.16
6	ADB	АРД КРЕДИТ ББСБ	1,540,248	122,798,606	81	72	-5.90
7	INV	ИНВЕКОР ББСБ	67,281	120,020,128	1,900	1,650	1.00
8	GOV	ГОВЬ	395,370	114,776,212	295	280	-2.73
9	APU	АПУ	199,622	113,255,077	582	559	-4.07
10	LEND	ЛЭНДМН ББСБ ХК	1,473,397	92,020,316.67	65	60.01	-7.43
11	MNP	МОНГОЛ ШУУДАН	117,029	71,009,397.8	650	555.01	-10.44
12	MFC	МОНОС ХҮНС	990,281	69,509,805.84	71.59	64	-2.87
13	SUU	СҮҮ	191,913	37,832,819	209	183	8.56
14	MNDL	МАНДАЛ ДААТГАЛ	6,451	33,345,695	5,400	5,085	0.58
15	TUM	ТҮМЭН ШУВУУТ	177,625	31,863,252	189	175	-5.14
16	AIC	АРД ДААТГАЛ ХК	31,430	22,642,476	748	680	-7.84
17	ADU	ХӨВСГӨЛ АЛТАН ДУУЛГА	19,512	13,417,706.7	710	667	4.96
18	ERDN	ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРАЙШН	26,476	13,192,381	540	449	-1.62
19	TCK	ТАЛХ ЧИХЭР	539	9,166,000	18,500	17,000	-0.58
20	HRM	ГЕРМЕС ЦЕНТР	68,779	8,159,143	140	110	-6.98



Ханшийн өсөлттэй хувьцаа

/2019.07.31-ний байдлаар/

№	Үнэт цаас нэр	Арилжигдсан Ширхэг/	Хаалтын ханш		Ханшийн өөрчлөлт /%/	Өөрчлөлт /%/
			2019-07-01	2019-07-31		
1	ХҮННУ МЕНЕЖМЕНТ	14	281.35	427.89	146.54	52.08
2	ДАРХАН ГУРИЛ ТЭЖЭЭЛ	46	1,051.00	1,597.00	546.00	51.95
3	Е-МОНИЕ	7	1,480.00	1,954.00	474.00	32.03
4	УБ-БҮК	277	315.00	399.00	84.00	26.67
5	МОНГОЛ БАЗАЛЫТ	894,961	293.00	360.00	67.00	22.87
6	МОГОЙН ГОЛ	7	6,600.00	8,000.00	1,400.00	21.21
7	АСБИ	70	462.00	531.30	69.30	15.00
8	ХҮРД	26	2,814.00	3,236.00	422.00	15.00
9	Э-ТРАНС ЛОЖИСТИКС	554	132.25	152.00	19.75	14.93
10	ДАРХАН ЗОЧИД БУУДАЛ	1,707	132.00	150.00	18.00	13.64
11	ШИВЭЭ ОВОО	239	2,104.00	2,380.00	276.00	13.12
12	ХИШИГ УУЛ	70	400.00	450.00	50.00	12.50
13	УЛААНБААТАР ХИВС	11,473	15,500.00	17,000.00	1,500.00	9.68
14	СҮҮ	191,913	188.83	205.00	16.17	8.56
15	ДАРХАН НЭХИЙ	220	14,000.00	15,000.00	1,000.00	7.14
16	АЛТАЙН ЗАМ	2	55,000.00	58,000.00	3,000.00	5.45
17	ХӨВСГӨЛ АЛТАН ДУУЛГА	19,512	674.53	708.00	33.47	4.96
18	РЕМИКОН	212,470	27.00	28.27	1.27	4.70
19	ЖУУЛЧИН ДЮТИ ФРИЙ	61	105,000.00	108,800.00	3,800.00	3.62
20	АЙТҮҮЛС	91,321	85.48	87.55	2.07	2.42

Ханшийн бууралттай хувьцаа

/2019.07.31-ний байдлаар/

№	Үнэт цаас нэр	Арилжигдсан / Ширхэг/	Хаалтын ханш (₮)		Ханшийн өөрчлөлт (₮)	Өөрчлөлт %
			2019-07-01	2019-07-31		
1	БӨХӨГ	120	3,200.00	2,200.00	-1,000.00	-31.25
2	ӨНДӨРХААН	10	3,660.00	2,660.00	-1,000.00	-27.32
3	ТЕХНИК ИМПОРТ	7	14,000.00	10,200.00	-3,800.00	-27.14
4	НИЙСЛЭЛ ӨРГӨӨ	25	5,015.00	3,700.00	-1,315.00	-26.22
5	НАКО ТҮЛШ	726	80.00	60.00	-20.00	-25.00
6	МОНГОЛЫН ЦАХИЛГААН ХОЛБОО	750	450.00	381.00	-69.00	-15.33
7	МОНГОЛ ШИЛТГЭЭН	164	350.00	297.50	-52.50	-15.00
8	СОР	150	1,149.00	977.00	-172.00	-14.97
9	АВТО ИМПЕКС	13	2,220.00	1,890.00	-330.00	-14.86
10	ЦАГААНТОЛГОЙ	2	1,900.00	1,625.00	-275.00	-14.47
11	ОЛЛЮО	850	68.00	60.00	-8.00	-11.76
12	ГУТАЛ	326	16,900.00	15,000.00	-1,900.00	-11.24
13	МОНГОЛ ШУУДАН ХК	117,029	691.16	619.00	-72.16	-10.44
14	ТАВАН ТОЛГОЙ	26,952	7,385.00	6,635.00	-750.00	-10.16
15	ДАРХАН ХҮНС	1	4,300.00	3,940.00	-360.00	-8.37



АНУ-С МОНГОЛ УЛСАД СУУГАА ЭЛЧИН САЙД МАЙКЛ С. КЛЕЧЕСКИ МХБ-Д ЗОЧИЛОО

2019 оны 7-р сарын 19-ний өдөр Америкийн Нэгдсэн Улсаас Монгол Улсад суугаа Элчин сайд Ноён Майкл С. Клечески болон тус Элчин сайдын яамны холбогдох төлөөлөгчид Монголын хөрөнгийн биржид зочилж, 6,017 дахь удаагийн үнэт цаасны арилжааг нээж цан цохилоо.

Энэхүү үйл явдлыг тохиолдуулан Гүйцэтгэх захирал Х.Алтай Элчин Сайд Клеческид МХБ-ийн үйл ажиллагааг танилцуулж, Монголын хөрөнгийн зах зээлийн цаашдын хөгжлийн боломжуудын талаар санал солилцлоо. Ёслолын үйл ажиллагааны үеэр Элчин сайд Майкл С. Клечески "Аливаа улсын эдийн засагт хөрөнгийн зах зээлийн гүйцэтгэх үүрэг асар чухал билээ. Монгол Улсын хөрөнгийн зах зээл идэвхжиж байгаа энэ цаг үед нэгэнт шинэчлэгдэн сайжирсан хууль эрх зүйн орчин, хуримтлуулсан туршлагадаа суурилан төрийн өмч хувьчлалыг МХБ-ээр дамжуулан хэрэгжүүлэх, тэр дундаа МХБ болон тооцооны байгууллагыг хувьчлах нь манай улсын төдийгүй олон улсын хөрөнгө оруулагчдыг татаж, Монголын хөрөнгийн зах зээл олон улсын зах зээл болоход чухал алхам болох юм" хэмээн онцлон тэмдэглээд, МХБ-ийн хүндэт зочны дэвтэрт гарын үсэг зурав.

ХАМТЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САН АЖИЛЛАХ БОЛОМЖ БҮРДЭНЭ

Сүүлийн жилүүдэд хөрөнгийн зах зээлд олон шинэ үнэт цаас амжилттай гарч, хөрөнгө оруулагчдын тоо нэмэгдэж, зах зээл идэвхжихийн хирээр зах зээлийн хөрвөх чадварыг хангах, тогтвортой байдлыг бий болгох асуудал тулгамдаж байгаа бөгөөд энэхүү асуудлыг шийдвэрлэхэд мэргэжлийн хөрөнгө оруулагчдын оролцоог нэмэгдүүлэх шаардлага үүсээд байна.

Мэргэжлийн хөрөнгө оруулагчид болох хөрөнгө оруулалтын сангуудын оролцоог нэмэгдүүлэхийн тулд тэдгээрийн нэгж эрхийг Бирж бүртгэж, арилжааг зохион байгуулснаар хөрөнгө оруулагчид биржээр дамжуулан хамтын хөрөнгө оруулалтын сангуудад хөрөнгө оруулж, оновчтой удирдлагаар хангагдах давуу талтай юм. Иймд МХБ-ээс "Хамтын хаалттай хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн бүртгэлийн журам"-ын төслийг боловсуулж, 2019 оны 5 дугаар сарын 10-ны өдөр Хороо, "АТТ" ХХК, МҮЦАЭХ, үнэт цаасны гишүүн компаниуд, хөрөнгө оруулалтын менежментийн компаниудын төлөөллийг оролцуулсан хэлэлцүүлгийг зохион байгуулж, дээрх байгууллагуудын саналыг бичгээр авч төсөлд тусгасан.

Түүнчлэн, журмын төслийг сар гарангийн хугацаанд өөрийн цахим хуудаст байршуулж, олон нийт, зах зээл сонирхогчид, судлаачдын саналыг авч тусгасны үндсэн дээр журмын төслийг эцэслэн боловсруулж МХБ-ийн ТУЗ-ийн 2019 оны 06 дугаар сарын 28-ны өдрийн 2019/07 тоот тогтоолоор батлуулан, Санхүүгийн зохицуулах хороогоор батламжлуулахаар хүргүүлээ.

"ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРАЙШН"- ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН АНХААРАЛД

Эрдэнэ Ресурс Девелопмент Корпорэйшн (TSX:ERD; MSE:ERDN) нь хаалттай хүрээнд нэмэлт үнэт цаас гаргах замаар \$2,001,500 кан.долларын хөрөнгө оруулалт амжилттай татан төвлөрүүлсэн тухай мэдэгдлээ. Татан төвлөрүүлсэн хөрөнгийг Компанийн Хөндий Алтны Төслийн хараат бус урьдчилсан ТЭЗҮ боловсруулах, Баян Хөндийн өрөмдлөгийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх, төслийн ашиглалтын тусгай зөвшөөрлийн өргөдөл, худалдан авалт болон эргэлтийн хөрөнгийг санхүүжүүлэх зэрэг үйл ажиллагаанд тус тус зарцуулахаар төлөвлөжээ.

Хурлаас гарах шийдвэрийн төсөл, түүнтэй холбогдох баримт бичигтэй танилцах журам, газар, ажиллах цаг:

Хувьцаа эзэмшигчид ажлын өдрүүдэд 09-17 цагийн хооронд "МОННАБ" ХК-ийн байранд ирэх эсвэл хурал зохион байгуулах комиссын гишүүдтэй холбогдон материалтай танилцах боломжтой.

Хурал зохион байгуулах комиссын дарга Ш.Оюун-Эрдэнэ; гишүүн Д.Болорцэцэг.

Хурал зохион байгуулах коммис: 91919392, 70172141

ЗАВХАН АЙМАГТ ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН НЭЭЛТТЭЙ ӨДӨРЛӨГ ЗОХИОН БАЙГУУЛЛАА

"Монголын хөрөнгийн бирж" ТӨХК нь орон нутгийн иргэдийн үнэт цаасны зах зээлийн талаарх мэдлэг, мэдээллийг дээшлүүлэх зорилгоор "Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв" ТӨХХК, "Гүүдсек ҮЦК" ХХК болон "Эрдэнэс Тавантолгой" ХК-тай хамтран "Үнэт цаасны зах зээлийн нээлттэй өдөрлөг" арга хэмжээг Завхан аймгийн Их-Уул, Тосонцэнгэл, Завханмандал, Улиастай, Отгон сумдад 2019 оны 7 дугаар сарын 22-ны өдрөөс 7 дугаар сарын 29-ний өдрүүдэд зохион байгууллаа.

Өдөрлөгийн үеэр хөрөнгийн зах зээлийн суурь ойлголтууд, хувьцаа, бондын арилжаанд хэрхэн оролцох, хөрөнгийн зах зээлээс компаниуд санхүүжилт татах боломж зэрэг сэдвээр сургалт явуулснаас гадна "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн санхүү, үйл ажиллагаа, иргэдэд олгосон хувьцааны талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, 1991 оны хөрөнгө оруулалтын эрхийн бичигтэй /ягаан цэнхэр тасалбар/ холбоотой дансны мэдээллийг шүүх, ногдол ашгийн мэдээллийг өгөх, үнэт цаасны данс нээх, иргэдийн өргөдөл гомдлыг хүлээн авч шийдвэрлэх зэргээр нийт 600 гаруй иргэдэд нэг цэгийн цогц үйлчилгээг үзүүллээ.



ХАРИЛЦАГЧ ШИЛЖҮҮЛЭХ УРАЛДААНТ ШАЛГАРУУЛАЛТ ЯВУУЛАХ ТУХАЙ ЗАРЛАЛ

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 87 дугаар зүйлийн 87.2.2, 87.4.1 дэх заалтыг үндэслэн “Үнэт цаасны брокер, дилер, андеррайтерийн үйл ажиллагаа эрхлэх этгээдэд онцгой нөхцөл байдал үүссэн тохиолдолд авах арга хэмжээний тухай журам”-ын дагуу үнэт цаасны зах зээлд зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл нь хүчингүй үнэт цаасны компанийн үндсэн харилцагчдыг бусад зохицуулалттай этгээдэд шилжүүлэх зорилгоор уралдаант шалгаруулалт зохион байгуулах комиссыг Хорооны даргын 2019 оны 445 дугаар тушаалаар байгуулсан билээ.

Иймд тусгай зөвшөөрөл нь хүчингүй болсон дор дурдсан 4 компанийн нийт 524 харилцагчдыг багцлан шилжүүлэхийг хүссэн үнэт цаасны зах зээлд үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий зохицуулалттай этгээд “Үнэт цаасны брокер, дилер, андеррайтерийн үйл ажиллагаа эрхлэх этгээдэд онцгой нөхцөл байдал үүссэн тохиолдолд авах арга хэмжээний тухай журам”-ын 5.2-т заасан материалыг бүрдүүлж, битүүмжлэн 2019 оны 8 дугаар сарын 26-ны өдрийн дотор Уралдаант шалгаруулалт явуулах комисст ирүүлнэ үү. Үүнд:

№	Үнэт цаасны компанийн нэр	Харилцагчийн тоо
1	"Фронттиер ҮЦК" ХХК	156
2	"Лондон Азия Капитал Монголиа ҮЦК" ХХК	2
3	"АБЖЯ ҮЦК" ХХК	360
4	"Зууны Гарц Секьюритис ҮЦК" ХХК	6
Нийт		524

Тус комисс нь уралдаант шалгаруулалтын материалыг хүлээн авах сүүлийн хугацаанаас хойш ажлын 10 хоногийн дотор дүгнэж, эрх хүлээн авагчид таницуулах ба эрх хүлээн авагч нь онцгой нөхцөл байдал үүссэн этгээдийн харилцагчдыг шалгарсан эрх бүхий компанид шилжүүлэх саналыг Хороонд ажлын 3 хоногийн дотор танилцуулах болно.

Жич: Нэмэлт мэдээллийг СЗХ-ны Хяналт шалгалт, зохицуулалтын газрын 51-261677 тоот утсаар холбогдож авна уу.

Үйл явдал

“ЭМ ДАБЛЮ ТИ ЭС ҮЦК” ХХК БОЛОН "ФРОНТИЕР ҮЦК" ХХК-ИЙГ МХБ-ИЙН ГИШҮҮНЧЛЭЛЭЭС ХАСЛАА

СЗХ-ны 2017 оны 9 дүгээр сарын 27-ны өдрийн 168 дугаар тогтоолоор үнэт цаасны зах зээлд зохицуулалттай үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөл нь цуцлагдсан “Эм Даблю Ти Эс ҮЦК” ХХК, СЗХ-ны 2019 оны 4 дүгээр сарын 24-ний өдрийн 81 дүгээр тогтоолоор мөн тусгай зөвшөөрөл нь цуцлагдсан "Фронттиер ҮЦК" ХХК-ийг МХБ-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2019 оны 6 дугаар сарын 28-ны өдрийн 2019/05 болон 2019/06 дугаар тогтоолоор Монголын хөрөнгийн биржийн гишүүнчлэлээс тус тус хаслаа.

“Эм Даблю Ти Эс ҮЦК” ХХК-ийн харилцагчдыг СЗХ-ны 2018 оны 4 дүгээр сарын 04-ний өдрийн хуралдаанаар МХБ-ийн гишүүн "Бумбат Алтай ҮЦК" ХХК-д шилжүүлж, нэмэлт төлбөр, зардал чирэгдэлгүйгээр үнэт цаасны дансаа үргэлжлүүлэн эзэмшиж, хөрөнгийн зах зээлийн харилцаанд саадгүй оролцох боломжийг бүрдүүлсэн билээ. Харин "Фронттиер ҮЦК" ХХК-ийн харилцагчийг шилжүүлэх тендер одоогоор зарлагдаагүй байгаа бөгөөд тендер зарлагдаж, СЗХ-ны холбогдох шийдвэр гарсны дараа тус компанийн харилцагчдад МХБ-ийн цахим хуудсаар шийдвэрийн тухай мэдэгдэх болно.

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН



Монгол Улс, Улаанбаатар
хот 15160

Чингис Хааны талбай-3

Монголын Хөрөнгийн Бирж



+976 11-313747



+976 11-325170



Info@mse.mn



WWW.MSE.MN